



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 03 сарын 23 өдөр

Дугаар А/21

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудлын үйл ажиллагаа
эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох тухай

Монгол улсын Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5. дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1, Газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ - Зочид буудалд тавих ерөнхий шаардлага MNS 4588:2008” стандартын шаардлагыг хангасан, тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.


2. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Аялал жуулчлал дэн буудал. Ерөнхий шаардлага MNS 5738:2007” стандартын шаардлагыг хангасан, тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Хангалуун трейд ХХК-ийн “Сэнтий” зочид буудлын 13/150, Налайх трейд ХХК-ийн “Янгир” зочид буудлын 15/008, Сүххайрхан ХХК-ийн “Цагаан-Од” дэн буудлын 16/079, Эбох ХХК-ийн “Солонго” дэн буудлын 17/026, Буянт онука ХХК-ийн “Тавлаг” дэн буудлын 16/141 гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4. Зөвшөөрөл авсан байгууллагуудтай гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-т үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг Үйлчилгээний байгууллага, стандарт хариуцсан мэргэжилтэн /Б.Амар/-д үүрэг болгосугай.

6. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг байгууллага бүрээс хураан, Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батбаатар/-д даалгасугай.

ДАРГА  Д.БАТСҮХ



1150500061

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2018 оны 03 сарын 03 өдрийн А/дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2018.03.23

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Хангалуун трейд ХХК	5123704	Сэнтий	СХД-ийн 18-р хороо ЭТӨЧ Москва 50 тоот
2	Налайх трейд ХХК	2604809	Янгир	НД-ийн 2-р хороо Партизаны 2-1
3	Эг тавт ХХК	4552814	Зобо	НД-ийн 1-р хороо Сургалтын задгай 3-26

--ooOoo--

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2018 оны 03 сарын 23
өдрийн Алт дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2018.03.23

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Буянт онука ХХК	6280579	Тавлаг	БЗД-ийн 5-р хороо өлгийн 28-363 тоот
2	Эбох ХХК	5377803	Солонго	СХД-ийн 16-р хороо 3-р үйлчилгээний төв 29-1
3	Сэнгэ наран ХХК	2093219	Өлзий	БЗД-ийн 6-р хороо 511г заал
4	Жой тройзон ХХК	5155908	Жи эл	БЗД-ийн 12-р хороо, Чулуут АОС 7-191 тоот
5	Мини макс ХХК	2008912	Багануур 24	БНД-ийн 3-р хороо, Нугын тал хэсэг
6	Огторгуйн цаг ХХК	5064635	Хас	БГД-ийн 20-р хороо Тээвэрчдийн зам 25-2 тоот
7	Баянцогт сонор ХХК	5300282	Сонор	СБД-ийн 9-р хороо Алтайн 12-352
8	Нью слетер ХХК	5124107	Өрнөх	СБД-ийн 11-р хороо Рашаантын 20-29
9	Сүх хайрхан ХХК	2825899	Цагаан од	СХД-ийн 13-р хороо өнөр хороолол 198/6

--ooOoo--